

Өлзийт сумын Засаг дарга болон ЗДТГазарт хандаж
иргэдээс ирүүлсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тухай

2020.12.23

Дундговь аймгийн Өлзийт сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт хандан иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол, санал хүсэлтийг шийдвэрлэхдээ холбогдох хууль журмын дагуу заасан хугацаанд нь чанартай шийдвэрлэж ирлээ. Иргэдийн санал, өргөдөл, гомдлыг шийдвэрлэхтэй холбогдсон зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 67 дугаар тогтоолыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон амаар, бичгээр, утсаар, цахимаар болон боломжит бүхий л хэлбэрээр хүлээн авч, шийдвэрлэлтийн явцыг улирал тутам Аймгийн ЗДТГазрын Төрийн захиргаа удирдлагын хэлтэст хүргүүлэн ажиллаж байна.

ЗДТГазар: Тус суманд үйл ажиллагаа эрхэлж буй “Жирмийн булаг” ХХК-ний шатахууны чанарын талаар төсвийн байгууллагын 4 жолооч, мөн 5 иргэнээс шатахууны шаталт муу чанаргүй байгаа талаар санал хүсэлт ирүүлснийг хүлээн авч тус компанид сумын Засаг даргын албан бичиг хүргүүлсэн. Тус компаний захирал Н.Батжаргал албан бичгийг хүлээн авч зохих арга хэмжээг авч ажиллаж буй талаар албан бичиг ирүүлсэн. Мөн Мэргэжлийн хяналтын газарт шатахууны дээжийг хүргүүлж, дүн шинжилгээний хариуг ирүүлсэн байна.

Гадны аймаг сумдын отор нүүдлийн малчид сумын нутаг дэвсгэрт олноороо ирж бусдын бууц хорооны ойролцоо бууж мөн Дорноговь, Говсүмбэр аймаг руу нүүдэл хийж дайран өнгөрч малын бэлчээр талхалж, өвлийн малын хоол өвс ногоог идэж, худаг усны хүрэлцээ хангамж муудаж байгаа зэрэг отор нүүдэлтэй холбоотой санал хүсэлт багийн Засаг нарт болон орон нутгийн удирдлагуудад малчдаас утсаар болон амаар удаа дараа ирснийг хүлээн авч ИТХ, Засаг дарга нар Албан мэдэгдлийг боловсруулж гадны аймаг сумын отор нүүдлийн малчдад хүргүүлэн зохих арга хэмжээ авч ажиллаж байна.

ИТХ-ын дарга, Засаг дарга, багийн Засаг дарга, цагдаагийн хэсгийн мөрдөгч, мал эмнэлгийн тасгийн дарга нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 1, 2, 3, 5-р багийн малчин өрхүүдээр явж одоогоор өөрийн сумын болон отор нүүдлийн 300 гаруй малчин өрхөд тус Албан мэдэгдлийг хүргүүлээд байна.

Нийтийн байрны гадна талд буй дулааны шугам сүлжээний хаалтнуудыг солих шаардлагатай болсныг иргэн М.Болормаа утсаар санал хүсэлтээ ирүүлснийг хүлээн авч зохих албан тушаалтанд уламжилж шийдвэрлэв.

Орчны бохирдол хог цэвэрлэгээний асуудалаар 4-н иргэнээс санал ирсний дагуу нийтийн эзэмшлийн талбай болон сум тойрсон эзэнгүй хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2 удаа зохион байгуулж, байгаль эхэд эрүүл агаар хоггүй цэвэр орчин бүрдүүлэв.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас нийтийг хамарсан ажил төслийн хүрээнд 5-н иргэнийг түр ажлын байраар хангаж сумын төвийн орчны цэвэрлэгээг хийлгэж хүрээлэн буй орчны өнгө үзэмжийг сайжруулав.

“Хоггүй цэвэрхэн Монгол” аяны хүрээнд жуулчны улирал эхлэсэнтэй холбогдуулан аймгийн БОАЖГазрын ажилчид, сумын байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагчид хамтран “Цагаан суварга” орчмын хогийг цэвэрлэж байгаль эхэд эрүүл агаар хоггүй цэвэр орчин бүрдүүлэв.

Сумын төвийн 3 иргэнээс нохой устгахтай холбоотой санал хүсэлт ирүүлснийг холбогдох арга хэмжээг авч 15 нохой устгасан байна.

Мал эмнэлгийн тасаг: Малчдаас ирсэн дуудлагыг хүлээн авч малын эмч, тархвар зүйч нар малчин өрхөд малын эрүүл мэндийн тусламж үйлчилгээг хүргэж ажиллалаа. Малчдаас ирүүлсэн малын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хүссэн дуудлага 22 ирж тухайн малчин өрхөд цаг алдалгүй шуурхай үйлчилсэн.

ЗДТГАЗАР